

Монгол-Зөвлөлтийн харилцаа (1925-1928)

Цэдэндамбын Батбаяр 

Академич, доктор Sc.D

Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс

tsedendamba.bud@gmail.com

Хураангуй: ОК(б)Н-ын Төв Хорооны Улс төрийн товчоо 1925 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар П.М.Никифоровыг ЗСБНХУ-аас Монголд суух Бүрэн эрхт төлөөлөгч бөгөөд худалдааны төлөөлөгчөөр томилох шийдийг гаргажээ. ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичерин түүнийг хүлээн авч уулзаад Монгол дахь Зөвлөлтийн зорилгыг “Бид Бүгд Найрамдах Монгол улсыг Хятадын протекторатын дор биеэ даасан автономит байдалтай байхыг ёс болгон тунхаглаж байгаа хэдий боловч бид Монголыг дотоод улс төр хийгээд эдийн засгийн байгуулалтаар зөвлөлтийн хэлбэрт ойртуулах практик ажлыг тэнд тууштай явуулах ёстой” гэжээ. Түүнчлэн Чичерин Никифоровт Дотоод Монголыг өөртөө нэгтгэх гэсэн Монголын Засгийн газрын хүсэлтийг хүлээж авахгүй, дэмжихгүй байх, Тагна Урианхайг Монголтой нэгэн адил статустай гэж үзэж байгаа тул Урианхайг Монголтой нэгтгэхийн эсрэг ажиллах заавар удирдамжийг өгч байжээ. ЗХУ, БНМАУ-ын эдийн засгийн харилцааг цаашид хөгжүүлэх үүднээс БНМАУ-д нэг сая алтан рублийн зээлийг 5 жилийн хугацаатай олгохоор 1925 оны 1 дүгээр сард шийдвэрлэсэн байна. Монгол улсын Засгийн газраас мөнгөний шинэчлэлт хийх ажлыг зохион байгуулах комиссыг 1925 онд 6 хүнтэй байгуулж, тус комисс нь мөнгөний шинэчлэлт, эргэлт хуримтлалын асуудлыг хариуцаж байв. Монгол улсын банкны анхны шинэ дүрэмд “Монголын хязгаарын дотор мөнгөний гүйлгээг журамтай болгох, үнийг тэгшитгэн бататгах, эд боловсруулах, мал үржүүлэх, худалдаа арилжааны зүйлийг бадруулах” гэжээ.

Түлхүүр үгс: БНМАУ, ЗХУ, санхүү мөнгөний шинэчлэл, монгол-зөвлөлтийн худалдаа, УБХ-ын төлөөлөгчийн айлчлал,



ЗХУ 1925 оны эхээр Монгол дахь санхүүгийн ажлыг өөрчлөн зохион байгуулах, мөнгөн тэмдэгт гаргах, Монгол банкны удирдлагыг солих, үндэсний аж үйлдвэр, тээвэр, холбоог хөгжүүлэх бодлогыг тодорхойлох зорилгоор А.О.Альский тэргүүтэй Санхүүгийн комиссыг томилон явуулах шийд гаргасан байна. Уг комисст БНМАУ-ын санхүүгийн байдал, Монгол банкны ажилд шалгалт хийх төдийгүй Монголын мөнгөний зах зээлийг Хятадын валютын хараат байдлаас чөлөөлж, БНМАУ болон ЗСБНХУ-ын хооронд эдийн засгийн ихээхэн бат нягт холбоо тогтоох нөхцөлийг бий болгох гэж тодорхойлж байв. Энэ зорилгод 2 сая рубль төсөвлөн гаргахаар болсон байна.¹

1925 оны эхээр А.Н.Васильевыг татан авч Ф.В.Линдег ЗСБНХУ-аас Монгол улсад суух Бүрэн эрхт төлөөлөгчөөр, Д.Д.Михельманыг Монгол банкны дарга бөгөөд санхүүгийн зөвлөхөөр баталсан хоёр чухал томилоо хийгдсэн байна. Линде 1925 оны 1 дүгээр сараас 7 дугаар сар хүртэл ердөө 6 хан сар Монголд ажилласан бөгөөд Ринчино-Рыскулов нарын зөрчил тэмцлийн төвөгтэй үе таарсан байна. Михельман 1922 оноос ЗХУ-ын Улсын банкны Москвагийн конторын захирлаар ажиллаж байгаад Монголд томилогдсон бөгөөд Монгол банкны даргаар 1927 оны 3 дугаар сар хүртэл 2 жил орчим ажилласан байна.

1925 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ЗХУ-ын Ардын комиссаруудын Зөвлөлийн гүйцэтгэх Хорооны тогтоолоор Монголын үйлдвэрлэх хүчийг хөгжүүлэх, ЗХУ, БНМАУ-

ын эдийн засгийн харилцааг цаашид хөгжүүлэх үүднээс БНМАУ-д нэг сая алтан рублийн зээлийг 5 жилийн хугацаатай олгохоор шийдвэрлэсэн байна.² Монгол улсын Засгийн газраас мөнгөний шинэчлэлт хийх ажлыг зохион байгуулах комиссыг 1925 онд 6 хүнтэй байгуулж, тус комисс нь мөнгөний шинэчлэлт, эргэлт хуримтлалын асуудлыг хариуцаж байв. Монгол улсын банкны анхны шинэ дүрэмд “Монголын хязгаарын дотор мөнгөний гүйлгээг журамтай болгох, үнийг тэгшитгэн бататгах, эд боловсруулах, мал үржүүлэх, худалдаа арилжааны зүйлийг бадруулах” гэжээ. Банкны эх мөнгө нь хоёр зуун тавин түмэн лан буюу түүнд тэнцэх таван зуун түмэн орос төгрөгөөр тогтоно гэж заажээ.³ Засгийн газрын шийдвэрээр 1925 оны 12 дугаар сарын 9-нөөс үндэсний мөнгөн тэмдэгтийг гаргаж гүйлгээнд оруулсан нь улсын санхүүгийн нэгдсэн системийг бэхжүүлэх нэг чухал хөшүүрэг болсон байна. Үүний үрээр мөнгөний шинэчлэлт 1925-1928 онд хэрэгжиж, 1928 он гэхэд Монголын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, хятадын доллар хоёр төлбөрийн гол хэрэгсэл болж бусад улсын мөнгө гүйлгээнээс хасагдсан ба 1929 оноос эхэлж зөвхөн төгрөгөөр бүх гүйлгээг хийх болжээ.

1925 оны 1 дүгээр сард БНМАУ-ын нутаг дэвсгэрт байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн ангиудыг нутагт нь буцаах асуудлаар хоёр улсын Засгийн газар ноот солилцсон байна.

² Государственный архив Российской Федерации /ГАРФ/, Ф.3316, Оп.2, Д.26, Л.4.

³ С.Ичинноров, М.Ринчин. Санжийн Довчин сайдын эдийн засаг, улс төрийн байр суурь.УБ., 1994.т.11-12.

¹ Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт 1920-1932.УБ., 2002.т.174-178.

СССР улсын Гадаад хэргийг эрхлэх яамны ардын комиссар Г.В.Чичеринээс 1925 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн “Зөвлөлтийн цэргийн ангийг Монголын нутгаас татах тухай” ноот бичигт 1921 оны 7 дугаар сараас өнөөг хүртэл Монголын нутаг дэвсгэрт байрлаж буй Холбоот улсын цэргийн ангиудын тухайд “...Монгол ба Зөвлөлт улсын цэргийн ангиудын сахилт хамгаалалтын дор Ардын засгаас хувьсгалын ажил хэргийг явуулж гүйцэтгэсний үрээр танай улсын дотор үнэхээрийн амар түвшин эмх журам зохиогдож улам цаашид улс ардыг ардчилсан ёсонд дэвшүүлж, Бүгд Найрамдах улс болгох ба агуу их бүх ард түмнийг Улсын хуралд зарлан хуралдуулах бололцоо нөхцөлүүдийг хангаж өгсөн болно. ...дээр дурдсан байдлаас үндэслэн мөн ч цагааны дээрэмчний үлдэгдлийг бүрнээ арилган устгасан учир Холбоот улсын цэргийн анги нь БНМАУ-ын хязгаарын дотор байрлан суух нь төдий л чухал бус гэж үзнэ” гэжээ.⁴

БНМАУ-ын Засгийн газрын Ерөнхий сайд Б.Цэрэндоржийн хариу ноотонд “...одоо манай дэвсгэр нутагт байгаа манай ах дүү болох СССР улсын улаан цэргийн ангиудыг эргүүлэн буцаах тухай өөрийн зөвшөөрсөн явдлыг илэрхийлнэ” гээд “...Улаан цэргийн ангиуд нь тус улсад 1921 оноос эхлэн 1925 он хүртэл байхдаа тэрхүү ангиудын олон дарга, улс төрийн ажилчид хийгээд бүх цэргүүд нь сахилга бат, соёл мэдрэл, ард түмэн ба засаг захиргааны газруудтай харилцах талаар...өөрийн сайн чанарын талыг илэрхийлсэн болохыг” тэмдэглээд “Ерөөс тохиолдох хүнд бэрх

цагуудад харилцан туслалцах ба үүний дотор ямар нэгэн учраас 1921 онд тохиолдсон байдалтай адил байдал манай улсад тохиодох бол манай ард түмэн ба Засгийн газар нь Холбоот улс ба түүний улаан цэргийн тусламжид хатуу батаар итгэж найдна” гэжээ.⁵

1969 онд хэвлэгдсэн “БНМАУ-ын түүх” зохиолын гутгаар ботид 1925 оны 1 дүгээр сард хоёр тал ноот бичгийг солилцсоны үндсэн дээр 1925 оны 3 дугаар сард тус улсаас зөвлөлтийн цэрэг бүрмөсөн гарчээ гэж бичсэн байна. Хэдий тийм ч үнэн байдал дээр зөвлөлтийн цэрэг бүрмөсөн гараагүй, ЗОУ-ын Бүрэн эрхт төлөөлөгчийн газрыг хамгаалах нэрийдлээр улаан цэргийн морьт дивизион Монголд үлдсэн байна. ОХУ-ын Гадаад хэргийн архивын баримтуудаас үзвэл Бээжинд сууж байсан Зөвлөлтийн Элчин сайд Л.М.Карахан Зөвлөлт-Хятадын хэлэлцээр байгуулагдсанаар улаан цэрэг Монголоос аргагүй гаргахад хүрэх тул Хятадаас өөрийгөө хамгаалах МАХЦ-ийг нэн даруй бэхжүүлэх саналыг Москвад удаа дараа тавьж, Зөвлөлт, Хятадын бага хурлыг Монголын армийг бэхжүүлэх хүртэл аль болох хойшлуулж ирсэн байна. Түүний санаачилгаар Бээжинд суугаа Зөвлөлтийн цэргийн атташе А.И.Геккер 1924 оны 4 дүгээр сард Нийслэл Хүрээнд ирж, МАХЦ-ийн байдалтай танилцаж, МАХЦ-ийг бэхжүүлэх саналыг Москвад тавьж байжээ.⁶

Ардын Засгийн газрын Цэргийн яамны сайд С.Магсаржав 1924 оны 11 дүгээр сард ЗХУ-д айлчлахдаа МАХЦ-ийн хэрэгцээнд зориулан Зөвлөлтийн талаас тодорхой тооны

⁴ БНМАУ хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд. Баримт бичгүүд. 1925-1940. Эмхэтгэсэн Ц.Насанбалжир. УБ., 1956. т.327-328.

⁵ Мөн тэнд. т.328-330.

⁶ Российско-Монгольское военное сотрудничество (1911-1946) Сборник документов. М., 2006.с.402-416.

зэр зэвсгийг хүсэхийн хамт Монголд үлдсэн зөвлөлтийн морьт дивизионыг цаашид ч үлдээхийг хүсэж байсан байна. Бүх цэргийн жанжин Х.Чойбалсан Москвад 1926 оны 5 дугаар сард очихдоо ч уг асуудлыг давтан тавьж байлаа.

ЗХУ-ын Гадаад хэргийн Ардын комиссариат /ГХАК/ нь Бээжингийн зүгээс Зөвлөлт, Хятадын бага хурал хийхийг хүчтэй шахах болсонтой холбогдуулан Улаан цэргийн морьт дивизионыг Улаанбаатарт улс төрийн зорилгоор тодорхойгүй хугацаагаар үлдээхээр 1925 оны эхээр шийдсэн байна.⁷ Эдгээрээс үзвэл Улаан цэргийг гаргасан тухай Зөвлөлтийн ГХАК-ын 1925 оны 3 дугаар сарын 6-ны мэдэгдэл, ноот бичиг зэрэг нь Монгол, Хятадын бага хурлыг хийлгэхийн тулд зохион байгуулсан Зөвлөлтийн дипломат нууц бодлогын үргэлжлэл байсан, Монголоос цэргээ гаргах ямар нэгэн хөдөлгөөн 1925 онд хийгдсэнгүй гэж зарим судлаачид үздэг.⁸ Зөвлөлтийн морьт дивизион 1928 оны намар өмч хэрэглэлийн хамт Монголоос гарчээ.

Өгүүлэн бүхий хугацаанд БНМАУ-ын цэргийн дээд удирдлагууд ЗХУ-д очиж зэвсэг техник худалдан авах талаар удаа дараа яриа хэлэлцээ хийж байв. ЦЯЯ-ны сайд С.Магсаржав, штабын дарга Д.И.Косич нар 1924 онд 2 сая шахам төгрөгийн, Бүх цэргийн жанжин Х.Чойбалсан, штабын дарга В.А.Кангелари нар 100 гаруй мянган төгрөгийн өртөг бүхий зэвсэг техник болон бусад хэрэглэл худалдан авчээ. Гэвч тус хоёр улсын хоорондын зэвсгийн худалдаанд зарим зөрчил

дутагдал гарч байжээ. БЦЗ-ийн тэргүүлэгч Н.Жадамба Улаан армийн ХЦЗ-д явуулсан нэгэн бичигтээ ЗХУ-аас худалдан авсан зэвсгийн дотор үнэ өртөг, зардал сүйтгэл ихтэй, манай орны нөхцөлд тохиромжгүй, андуурч явуулснаас сум нь үл таарах зэвсэг техник удаа дараа ирсэн учир сольж өгөхийг хүсэж байв.⁹

ОК(б)Н-ын Төв Хорооны Улс төрийн товчоо 1925 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар П.М.Никифоровыг ЗСБНХУ-аас Монголд суух Бүрэн эрхт төлөөлөгч бөгөөд худалдааны төлөөлөгчөөр томилох шийдийг гаргажээ. Никифоровын хувийн тэмдэглэлд бичсэнээр Г.В.Чичерин түүнийг хүлээн авч уулзаад Монгол дахь Зөвлөлтийн зорилгыг “Бид Бүгд Найрамдах Монгол улсыг Хятадын протекторатын дор биеэ даасан автономит байдалтай байхыг ёс болгон тунхаглаж байгаа хэдий боловч бид Монголыг дотоод улс төр хийгээд эдийн засгийн байгуулалтаар зөвлөлтийн хэлбэрт ойртуулах практик ажлыг тэнд явуулах ёстой” гэжээ. Түүнчлэн Чичерин Никифоровт Дотоод Монголыг өөртөө нэгтгэх гэсэн Монголын Засгийн газрын хүсэлтийг хүлээж авахгүй, дэмжихгүй байх, Тагна Урианхайг Монголтой нэгэн адил статустай гэж үзэж байгаа тул Урианхайг Монголтой нэгтгэхийн эсрэг ажиллах заавар удирдамжийг өгч байжээ.¹⁰

П.М.Никифоров Монголд очихын өмнө Зөвлөлт-Монголын эдийн засгийн харилцааны талаар “Монголд одоо манай хоёр хүчирхэг байгууллага ажиллаж байгаа нь Сибирийн

⁷ АВП РФ, Ф.8, Оп.10, П.32, Д.175. Л.1-3.

⁸ Р.Болд. Бүрэн эрхээ хязгаарлуулсан тусгаар тогтнол. УБ., 2021. т.155-157.

⁹ Монгол цэргийн түүхийн товчоон.Дэд дэвтэр.УБ., 1996. т.226-227.

¹⁰ Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт 1920-1932.УБ., 2002. т.192-195.

улсын худалдааны газар /Сибгосторг-Ц.Б./, “Ноос” буюу “Шерсть” нийгэмлэг хоёр юм. “Ноос” нийгэмлэг нь “Кауфман ба андууд нар” гэдэг гадаадын томоохон пүүсийн Монгол дахь бэлтгэн нийлүүлэх өргөн сүлжээг худалдаж авчээ” гэж өөдрөгөөр бичиж байв. Өгүүлэн буй үеийн Монгол, Зөвлөлтийн худалдааны харилцаа нь 1923 оны хоёр орны худалдааны хэлэлцээрийн үндсэн дээр хөгжиж байв. Тэр хэлэлцээрийн ёсоор Монголд ажиллаж байсан Зөвлөлтийн худалдааны Центросоюз, Сибгосторг, Дальгосторг пүүсүүд болон хувь нийлүүлсэн “Шерсть”, “Чикойн арьс ширний заводын төлөөлөгчийн газар” зэрэг худалдааны газрын үйл ажиллагаа өргөжин тэлж байв. Монгол Ардын засгийн газар зөвлөлтийн худалдааны пүүсүүдийг дэмжиж, Монголын харилцан туслалцах Хоршоог /МХТХ-Ц.Б./ юуны урьд тэдэнтэй худалдаалж байх, гадаадын пүүсүүд зөвлөлтийнхөөс хамаагүй илүү үнэ өгч байсан ч Зөвлөлтийн пүүсүүдтэй эхлэн худалдаа хийж байх заалтыг өгч байв. Ардын Засгийн газар “Шерсть” худалдааны байгууллагад 750 мянган рублиэр хувь нийлүүлэгчээр оржээ. Мөн 1925 онд Ардын Засгийн газар Москвад өөрийн худалдааны төлөөлөгчийн газрыг нээжээ.¹¹

ЗХУ-ын Бүрэн эрхт төлөөлөгч П.М.Никифоров 1926 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хувийн тэмдэглэлдээ Монголд ирж ажиллаад 8 сарын хугацаанд хоёр талын харилцааны асуудлаар Ардын Засгийн газартай шийдэж зохицуулсан асуудлуудаа дараах байдлаар томъёолжээ. Үүнд:

1. Урианхайн асуудал (Ардын Засгийн газар Урианхайд өнгөлзөхөө больсон)
2. Монголд гаалийн шинэчлэл
3. Зөвлөлтийн хүн эмнэлгийн экспедиц ирэхээр болсон,
4. Английн Вильсон компанитай байгуулсан гэрээг цуцлахаар болсон,
5. Цэдэн-Иш Гочитскийг Монценкоопоос зайлуулах
6. Монгол-Зөвлөлтийн ажил хэрэгч хүмүүсийн клуб байгуулах
7. ЗСБНХУ-ын иргэдийн байдлын тухай ярьж тохирох
8. Төвөдөд албан ёсны төлөөлөгч явуулах гэжээ.¹²

Харин ардын засагтай хараахан тохирч шийдэж чадаагүй байгаа асуудлын тоонд ан агнуурын асуудал, Монголын гол мөрнөөр хөлөг онгоц явуулах тухай, Мал эмнэлгийн конвенцын тухай асуудал багтаж байв. Тухайлбал, Никифоров Ерөнхий сайд Б.Цэрэндоржид Монголын гол мөрөн, нуур усанд хөлөг онгоц тавих тухай, мал эмнэлгийн конвенц байгуулах тухай, Монголын ой хөвчид зөвлөлтийн иргэд ан гөрөө хийх журмын тухай гурван ч асуудлыг их шаргуу тавьж байжээ. Ерөнхий сайд эдгээр асуудлаар ЗСБНХУ-д тааламжтай байдлаар хэлэлцээр байгуулж болох юм, гэвч хятадууд мөн тиймэрхүү буулт хийлгэх гэж шаардах вий хэмээн болгоомжилж байжээ. Ерөнхий сайд ялангуяа мал эмнэлгийн экспедиц ирүүлэх асуудал дээр тун болгоомжтой хандаж байв. Оросууд бүр 1921 онд Монголд мал эмнэлгийн орлогыг бүрэн хяналтдаа авахыг оролдож байсныг сануулж,

¹¹ Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх. 1921-1978. УБ., 1981, т.104-105.

¹² XX зууны 20-иод оны тэмдэглэлүүд. Эмхэтгэсэн Д.Өлзийбаатар. УБ., 2007. т.52.

одоо ч оросууд хүн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх аргаар чухамдаа Монгол дахь мал эмнэлгийн орлогыг булааж авахыг эрмэлзэж байна гэж үзэж байжээ.¹³

П.М.Никифоров нарын хүчин чармайлтаар 1926 оны 6 дугаар сарын 8-нд Холбоот улсын галт онгоцны Сэлэнгийн ангиас Монголын хязгаар дотор Орхон, Сэлэнгэ голууд ба мөн голуудын салбар усаар сангийн худалдааны онгоц нааш цааш явуулах тухай “Галт онгоц явуулах тухай Монгол, Зөвлөлтийн гэрээ”-г байгуулжээ. Мөн ЗХУ ба БНМАУ-ын хооронд цахилгаан мэдээгээр харилцах тухай хэлэлцээрийг 1930 оны 5 дугаар сарын 20-ны өдөр, Малын халдварт өвчинтэй тэмцэх тухай Монгол-Зөвлөлтийн конвенц гэдэг гэрээ бичгийг 1930 оны 5 дугаар сарын 20-ны өдөр тус тус байгуулсан байна.¹⁴

Зөвлөлтийн тал Монголын Засгийн газар Америк, Английн пүүсүүдтэй хамтран ажиллах, ялангуяа мөнгөний их дүнтэй яриа хэлэлцээр хийх явдалд туйлын эмзэг хандаж, эрс тэс таслан зогсоох арга хэмжээ авч байв. Эхний асуудал нь “Монголор” түрээсийн гэрээг америкийн талтай байгуулах асуудал байв. Монголд америкийн капиталыг нэвтрүүлэх нь хүсүүштэй зүйл биш хэмээн үзэж “Монголор” түрээсийн гэрээ байгуулах Монголын Засгийн газрын үзэл бодол, бүхий л нөхцөл болзлыг тодруулж, түрээсийн гэрээ зайлшгүйд хүрвэл түүнд ЗСБНХУ-ын зүгээс хяналт тавих нь чухал гэж үзэж байв. ОК/б/Н-ын Төв Хорооны Улс төрийн товчоо 1925 оны 6 дугаар сарын 11-ний хуралдаанаар “Монголор”-ын тухай

хэлэлцээд ЗСБНХУ “Монголор” хэмээх үйлдвэр аж ахуйн ажилд оролцох боломжгүйг мэдэгдэх, Монголын Засгийн газарт Германы капиталыг татан оролцуулах санал тавьж, тийнхүү татан оролцуулахад Зөвлөлтийн тал хүч хавсрахад бэлэн байгааг мэдэгдэж байжээ.¹⁵

Хоёр дахь асуудал нь МХТХ буюу Монценкоопоос Английн Вильсон компанитай байгуулсан ноос, түүхий эд бэлтгэх гэрээ байв. БНМАУ дахь Зөвлөлтийн бүрэн эрхт төлөөлөгч П.М.Никифоров Монголын харилцан туслалцах хоршоо Английн Вильсон пүүстэй ноос бэлтгэлийн гэрээ байгуулсныг шаргуу эсэргүүцэн цуцлуулж, уг гэрээг байгуулсан МХТХ-ны Ерөнхий хорооны дарга Д.Цэдэн-Иш /Гочитский/-ийг албан тушаалаас нь огцруулахаар МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдэд шахалт үзүүлж, 1925 оны эхээр түүнийг ажлаас нь огцруулж, Москвад Монценкоопын төлөөлөгчөөр томилон явуулах шийд гаргуулжээ. Тэр ч байтугай БХК/б/Н-ын Төв Хорооны Улс төрийн товчоо 1926 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар Монценкоопын Вильсон компанитай байгуулсан гэрээний тухай хэлэлцэж, Зөвлөлтийн “Шерсть” компанид Вильсон компанийн худалдаж авсан дээр нэмж ноос худалдан авахыг зөвшөөрөхгүй, мөнгө олгохыг хойшлуулах тухай шийд гаргаж байв.¹⁶

АЗГ-ын Ерөнхий сайдын жинхэнэ орлогч бөгөөд Аж ахуйн яамны сайд, Эдийн засгийн зөвлөлийн дарга А.Амар, МАХН-ын Төв Хорооны орлогч дарга, Засгийн газрын эрхлэх

¹³ Мөн тэнд. т.28-31.

¹⁴ БНМАУ хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд. Баримт бичгүүд. 1925-1940. УБ., 1956. т.331-342.

¹⁵ Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт 1920-1932. УБ., 2002. т.191..

¹⁶ Мөн тэнд. т.213.

товчооны гишүүн Н.Жадамба нар 1926 оны 2 дугаар сард ЗХУ-д айлчилсан байна. Энэ айлчлалын тухай Улаанбаатарт суугаа ЗХУ-ын Бүрэн эрхт төлөөлөгчийн газраас Гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичеринд явуулсан бичигт: “Аж ахуйн яамны сайд Амар ЗХУ-д хоёр зорилготой явж байна. 1-рт, Монголтой удам угсаа нэгтэй ард түмнүүд шинэ байгууллын нөхцөлд улс төр, эдийн засгийн хувьд үнэхээр хэр зэрэг сайжирч чадсаныг шалгах, 2-рт, манай аж үйлдвэр, хөдөө аж ахуйтай танилцаж зээлийн асуудал боловсруулах явдал юм. ...Тэр оросоор ярьдаггүй боловч гайгүй ойлгодгийг яриандаа анхаарна биз...Амар бол сүрхий хүн, чин сэтгэлийн ба өнгөн талын хандлагын ялгааг гаргууд сайн мэднэ” гэж анхааруулж байжээ.¹⁷

А.Амар, Н.Жадамба нар ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичеринтай уулзаж, Монгол, Зөвлөлтийн эдийн засаг, худалдаа, санхүүгийн харилцаанд 1920-иод оны дундуур гарч байсан зохисгүй явдал, эдийн засгийн харилцааны хэтийн төлөвийн талаар ярилцаж санал солилцсон бөгөөд уулзалт ярианы явцад хөндсөн асуудлуудаар санамж болгон хувийн захидал бичиж Чичеринд өгчээ. Уг захидалд “Тантай нүүр учирч хэлэлцэхэд Монгол улс, ЗХУ-ын хоорондын эдийн засгийн харилцаанд ажиглагдаж буй үл нийлэлцэх зүйлүүд ба энэхүү харилцах явдлыг сайжруулан нэгэн замд оруулах тухай Танд сонордуулах завшаан тохиолдсон билээ” гээд санхүү, эдийн засгийн шинжтэй асуудлуудыг улс төрийн ерөнхий асуудлаас тусад нь салангид авч үзэх

аргагүй гэж тэмдэглээд, тэдгээр үл нийлэлцэх явдлын дийлэнх нь хоёр талын аль нэг хүний хувийн нөлөө юм уу, хэн нэгэн ажилтны үүрэг, хариуцлагаас болж үүсэж байгаа бус, харин улс төрийн ерөнхий бодлогын асуудлаар нэгдсэн үзэл баримтлал, харилцан тохиролцсон зохицуулалт байхгүй байгаатай холбоотой гэж бид баттай үзэж байна. Ийм нөхцөлд Монгол улс ЗХУ-ын хоорондын улс төрийн ерөнхий харилцаа нь эрх тэгш талуудын хамтын ажиллагаа, найрамдлын холбоо, харилцан туслах харилцааны зарчимд тулгуурласан байх ёстой гэдгийг нэгэн уг үндэс болгож, ямагт хэвшүүлэн тогтоож бэхжүүлэх нь зайлшгүй чухал мэт санагдана гээд аж ахуйн асуудлууд нь

1. Худалдаа ба худалдааны бодлогын
2. Аж үйлдвэрийн
3. Тээх нэвтрүүлэх (тээврийн) явдал
4. Банкны бодлого ба банкны практикийн гэсэн үндсэн 4 бүлэг болж байна гэжээ.¹⁸

Амар, Жадамба нарын захидалд: хоёр орны худалдаа, Монголд аж үйлдвэрийг хөгжүүлэх, тээх нэвтрүүлэх явдал, банк санхүү зэрэг салбарт гарч буй үл нийлэлцэх зүйлүүдийг ил тодоор бичиж, тэдгээрийг хэрхэн засаж сайжруулах талаар санал бодлоо илэрхийлжээ.

Үүнд худалдааны салбарт:

- Зөвлөлтийн худалдааны байгууллагууд монголын түүхий эдийн үнийг элдэв арга хэрэглэн бууруулах, үнэ буурах улирлын үед хааж боогдуулах, гадаадаас нэвтрүүлэх барааг хэтэрхий ихээр буюу хэтэрхий хомсоор оруулах

¹⁷ Ерөнхий сайд А.Амар: Үзэл бодол, үйл ажиллагаа. Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн намтрын товчоон. ХҮ боть. УБ., 2012. т.40-41.

¹⁸ МУУТА, УТНОНББТ, Х-4, Д-2, ХН.131, хуудас 65-73.

- Зөвлөлтийн байгууллагууд зарим бараанд онц эрх эдэлж буйгаа ашиглан чөлөөтэй өрсөлдөхийг боож, үнийг бага болгох явдалд саад хийх,
- Холбоот улсад Монгол хоршоог саадгүй худалдаа эрхлэх явдлыг сахин хамгаалах
- Холбоот улсаар нааш, цааш нэвтрүүлэх, мөн Холбоот улсын хязгаарт оруулсан эд барааг шууд нэвтрүүлэх эрхийг Монгол улсад олгох
- Зөвлөлтийн байгууллагууд хятадын жижиг шунахай худалдаачдыг ашиглан хэрэглэх явдлыг зогсоох,
- Холбоот улсад худалдаалах Монголын газруудад, мөн Монголын газрын онц байдлыг дагуулж худалдааны хэрэгт удаан хугацааны тусгай хөрөнгө зээлүүлэх гэсэн тодорхой саналуудыг хүргүүлж байжээ.

Аж үйлдвэрийн салбарт:

- ЗХУ Монголд үндэсний аж үйлдвэр байгуулах явдлыг үл харгалзан, өөрийн хөрөнгө капиталыг оруулж булигаар боловсруулах зэргийн аж үйлдвэрүүдийг байгуулж, манай хоршоо ба улсын газруудаас аж үйлдвэрийн явдлыг хөгжүүлэхээр эрхлэн буй явдлыг устгах эс бөгөөс гүйцэтгэх явдлыг их л саатуулан боогдуулахад хүргэж буйг анхаарч үзэх

Банкны салбарт:

- Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банкны эрх баригчдын олонх болох оросын харьяат нар Холбоот улсын эрх ашгийг тэргүүнд тавьж, зөвлөлтийн

хоршоолон худалдаалах газруудын ашиг тусыг онц болгон явуулж буй

- Монголын харилцан туслалцах хоршоог доорд үзэж, ажлыг саатуулан мөнгө зээлүүлэхгүй буюу зээлдүүлэхэд удаашруулан чухал цагийг алдуулах зэрэг явдал гаргаж буйг дурджээ.¹⁹

Монгол дахь эдийн засгийн ажлын тухай БХК/б/Н-ын Улс төрийн товчооны Монголын Комиссын хуралдааны 1926 оны 5 дугаар сарын 15-ны протоколоос үзвэл А.Амар нарын Чичеринд бичсэн захидалд тусгагдсан асуудлуудыг цэгцлэх талаар зөвлөлтийн тал тодорхой арга хэмжээ авсан нь харагдаж байна. Үүнд: барааны нэр төрөл нь монголын эд хэрэглэгчдэд яг тохирсон бөгөөд зөвлөлтийн бараа таваар үнэ өртгийн байдлаар гадаадынхантай өрсөлдөж чадахуйц, тийм таваарын нөөцөөр хангаж байх, Монголд хэрэгтэй бөс бараа /даалимба, цууямбуу/ яаравчлан үйлдвэрлэх эрс арга хэмжээ авах, Монголд ажиллаж байгаа зөвлөлтийн байгууллагууд хоорондоо өрсөлдөх, эсвэл Монценкооптой өрсөлдөх явдлыг зогсоох, Монценкооп болон Монголд ажиллаж байгаа зөвлөлтийн байгууллагуудын бүрэлдэхүүн бүхий холимог нийгэмлэг байгуулах гэж тогтоожээ. Санхүүгийн хувьд бараа тус бүр дээр нэг бүрчлэн капиталын эргэлт ямар байгааг харгалзан Монголын экспорт, импортын талаар Монценкооптой хамтран ажиллаж буй зөвлөлтийн байгууллагуудад 12 сар хүртэл хугацаатай зээл олгохыг Улсын банк, Монгол банканд үүрэг болгох, 1927 он гэхэд хүлээсэн бүх үүргийг валютжуулж, Монголд хийх бүх тооцоог монгол төгрөгөөр

¹⁹ “Үнэн” сонин, 1989.11.29. №285

хийх бололцоотой болгохын тулд нэлээд хэдэн бэлтгэл арга хэмжээ авахыг даалгажээ.²⁰

Монголд үйл ажиллагаа эрхэлж, зарим үед хоорондоо өрсөлдөж байсан Зөвлөлтийн худалдааны байгууллагуудыг цэгцлэх үүднээс Зөвлөлт Засгийн газраас 1,5 сая рублийн дүрмийн сантай “Стормонг” хувь нийлүүлсэн нийгэмлэгийг байгуулж, 1927 оны 6-р сарын 1-нээс эхлэн Монголын нутагт Зөвлөлтөд үйлдвэрлэсэн бараа таваар худалдан борлуулах, түүхий эд бэлтгэх ажлыг явуулах болжээ. Үүний дагуу “Ноос” болон бусад зөвлөлтийн бүх байгууллагуудын ажлыг зогсоосон байна.²¹

БХК/б/Н-ын Төв Хорооны Улс төрийн товчоо 1927 оны 7 дугаар сарын 14-нд Монголтой эдийн засаг, худалдааны хэлхээ холбоогоо бэхжүүлэх тухай Дотоод болон гадаад худалдааны ардын комиссар А.И.Микояны саналыг авч хэлэлцээд зарим эрс арга хэмжээ авчээ. Үүнд:

- БНМАУ болон ЗСБНХУ-ын хооронд худалдааны гэрээ байгуулахаар хэлэлцээ хийж эхлэх,
- Монголд худалдах зөвлөлтийн барааны үнийг чанар нь тохирох гадаад гаралтай барааны үнээс илүүгүй байлгах
- Монголын зах зээлийн хэрэгцээг зөвлөлтийн аж үйлдвэрийн төлөвлөгөөнд оруулж, барааны чанар, нэр төрөл зэргийн талаар Монголын зах зээлийн бүхий л онцлогийг харгалзан бараа үйлдвэрлэх

²⁰ Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт 1920-1932. УБ., 2002. т.214-217.

²¹ Б.А.Асонов, Б.М.Петров. Экономическое сотрудничество Советского Союза с МНР.М., 1971. с.24-25.

- Монценкооп /4 сая рубль хүртэл/ болон Зөвлөлтийн экспорт-импортын байгууллага Стормонг-д зээл олгох явдлыг нэмэгдүүлэх,

- Манайхыг Монголтой холбосон зам харилцаа, нэн тэргүүнд Дээд-Үд-Хиагтын замыг засах, гол мөрний тээврийг зохицуулах, Монголын ажиллагааг гүйцэтгэхдээ манай байгууллагын зүгээс тээвэр-илгээлтийн ажиллагааны зардлыг бууруулахад онцгой анхаарах зэрэг арга хэмжээ авчээ.²²

1926 оны 4-5 дугаар сард БНМАУ-ын Бага хурлын дарга П.Гэндэн тэргүүтэй 17 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид ЗХУ-ын үйлдвэр, аж ахуй, соёлын хөгжилтэй танилцахаар ЗХУ-д айлчилсан байна. Монголын парламентын төлөөлөгчдийн анхны айлчлалыг Октябрийн хувьсгалын 9 жилийн ой, 1921 оны Ардын хувьсгалын 6 жилийн ойн жил зохион байгуулсан байна. Төлөөлөгчид эхлээд Буриад Монголын нийслэл Дээд-Үдэд хүрч Ерөнхий сайд Ербанов Монголын төлөөлөгчдийг хүлээн авч уулзан баяр хүргэжээ. Төлөөлөгчид 4 дүгээр сарын 20-ны өдөр Москва хотод хүрч, Гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичерин, Холбоот улсын Бага хурлын дарга М.И.Калинин, Гадаадтай эрдэм соёлын хувиар харилцах газрын дарга Каменева нар хүлээн авч уулзаж, ЗХУ-ын Газар тариалангийн яам, Эрүүлийг хамгаалах яам, улаан цэргийн сургууль, Дорно зүгийн эв хамт намын сургууль /КУТВ/, талх чихрийн фабрик, хөдөө аж ахуйн газрууд, мал эмнэлгийн сургууль зэрэг үйлдвэр, аж ахуй, соёлын олон газруудад зочлуулсан байна. Ө.Бадрах нарын 10 хүн мөн айлчлалын үеэр Ленинград хотод зочилж,

²² .Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт 1920-1932. УБ., 2002. т.233-234.

Ленинград хотын намын хороонд уулзалт хийж, Ленинград хотын Дорно дахины хэл бичгийн сургууль, зоосны завод, төмрийн завод, оёдлын фабрик, газрын хөрс шинжих музей зэрэгт зочилж, Майн нэгний жагсаалыг Ленинград хотод үзэж сонирхжээ.²³

УБХ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд УБХ-ын дарга П.Гэндэн, НТХ-ны нарийн бичгийн дарга Г.Гэлэгсэнгэ нараас гадна С.Довчин, Ө.Бадрах, Шатар, Пунцаг, Мэндбаяр, Ц.Жигжиджав, Ж.Дамдинсүрэн, Дарьжав, Дугар, Хорлоо, Сандагсүрэн, Заяат, УБХ-ын эмэгтэй гишүүн Дашдондой, Цэрэнлхам, Ёндон нар багтжээ. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг авч үзвэл 2-хон жилийн дараа “зүүнтэн” хэмээн нам төрийн эрхэнд гарч ирсэн П.Гэндэн, Ө.Бадрах, Ц.Жигжиджав, Ж.Дамдинсүрэн нарыг төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оруулсан нь санамсаргүй явдал биш байв. Айлчлал хэдийгээр Монголын парламентын төлөөлөгчдийн ЗХУ-д хийж буй анхны айлчлал гэдгээр ёслолын чанартай байсан боловч П.Гэндэн, Ө.Бадрах нар голлож байсан “хөдөөгийн” буюу “зүүнтний” бүлгийн удирдагчдыг ЗХУ-д анх удаа айлчлуулж, тэдний нэр хүндийг өргөх, ЗХУ-д өрнөж буй социализмыг бүтээн байгуулах хөгжилтэй танилцуулах, Монголын улс төрийн тавцанд тэднийг гаргаж ирж, үндэсний эрх ашгаа дээдэлж, ЗХУ-тай тэгш эрхтэй харилцахыг эрмэлзэж байсан Ц.Дамбадорж, Н.Жадамба нарыг зайлуулахад бэлтгэл хүчин болгож бэлтгэх зорилго давхар агуулж байсан нь тодорхой.

Өгүүлэн бүхий жилүүдэд Ц.Дамбадорж, Г.Гэлэгсэнгэ, Ц.Жамсран, Н.Жадамба нарын

Монголын улс төрийн удирдагчид МАХН-ын III их хурлын тогтоолын “Харгис капиталтан хөрөнгөтний дарлагдал зовлонг үл амсан, олон улсын одоогийн байдалд нийлүүлэн жинхэнэ ардын ёсыг баримтлах” заалтыг мөрдлөг болгож, ард олны эрх ашигт аль болох нийцтэйгээр дотоод, гадаад бодлогыг хэрэгжүүлэхээр эрмэлзэж байсан үе байв.

Тэд өөрсдийн үндэсний ардчилсан цэгц үзэл баримтлалын дагуу дэлхий дахины байдал, улс орны гадаад, дотоод бодит байдалд зөв зүйтэй дүн шинжилгээ хийж, Монгол-Зөвлөлтийн харилцааг тэгш эрхтэй, харилцан ашигтай зарчмаар хөгжүүлэх бодлого баримталж байсан байна.

²³ МУУТА, УТНОНББТ, Х-4, Д-2, ХН-132.

Ном зүй

Нэг. Архивын эх сурвалж

- Монгол Улсын Үндэсний төв архив (МУУТА).
- МУУТА, УТНОНББТ, Х-4, Д-2, ХН.131, хуудас 65-73.
- МУУТА, УТНОНББТ, Х-4, Д-2, ХН-132.
- Государственный архив Российской Федерации (ГАРФ), Ф.3316, Оп.2, Д.26, Л.4.
- Архив Внешней политики РФ, Ф.8, Оп.10, П.32, Д.175. Л.1-3.

Хоёр. Хэвлэгдсэн архивын баримтууд

- БНМАУ хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд. Баримт бичгүүд. 1925-1940. Эмхэтгэсэн Ц.Насанбалжир. УБ., 1956.
- Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт 1920-1932. УБ., 2002
- XX зууны 20-иод оны тэмдэглэлүүд. Эмхэтгэсэн Д.Өлзийбаатар. УБ., 2007.
- Российско-Монгольское военное сотрудничество (1911-1946) Сборник документов. М., 2006.

Гурав. Судалгааны зохиолууд

- Б.А.Асонов,Б.М.Петров.Экономическое сотрудничество Советского Союза с МНР. М., 1971.
- Р.Болд. Бүрэн эрхээ хязгаарлуулсан тусгаар тогтнол. УБ., 2021.
- С.Ичинноров, М.Ринчин. Санжийн Довчин сайдын эдийн засаг, улс төрийн байр суурь. УБ., 1994.
- Ерөнхий сайд А.Амар: Үзэл бодол, үйл ажиллагаа. Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн намтрын товчоон. ХҮ боть. УБ., 2012.
- Монгол цэргийн түүхийн товчоон. Дэд дэвтэр.УБ., 1996.

Дөрөв. Тогтмол хэвлэл

- “Үнэн” сонин, 1989.11.29. №285

Mongol-Soviet Relations (1925-1928)

Batbayar Tsedendamba

Academician, Sc.D

Institute of History and Ethnology, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
tsedendamba.bud@gmail.com

Abstract: *The article explores the aspects of the interaction between Mongolia and the USSR on the development of their bilateral relations starting from 1925 up until 1928. The author shows how the Soviet troop withdrawal issue created by Moscow influenced the settlement of disputed issues between Mongolia and China, and interfered into the normalization Mongolian-Chinese relations for many years. Soviet envoy to the MPR P.M.Nikiforov was tasked to carry out total sovietization of all aspects of Mongolian life under the nominal cover of independent Mongolia, and to prevent any process of unification between Outer and Inner Mongolia, to urge Mongolian leaders to recognize Tannu Tuva People's Republic without any preconditions. A.Amar, Minister for Economy, during his trip to Moscow early 1926 raised the issues of distorted Mongol-Soviet trade, industrial, transport and other bilateral economic relations and asked Moscow to make adjustments and make economic relations equal and mutually beneficial. The character of the atmosphere between Ulaanbaatar and Moscow did play a key role in solving difficult and sensitive bilateral issues and the desire of the Mongolian People's Republic to build official relations with Moscow as equal and trustful partners was strong.*

Keywords: *the MPR, the USSR, finance-monetary reform, mongol-soviet trade, Little Hural delegation's visit*

<i>The day of submission:</i>	2023.04.13
<i>Completion of review:</i>	2023.04.27
<i>Final decision for acceptance:</i>	2023.05.04